

## МОНГОЛБАНКНЫ МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛИЙН ТОВЧЛОЛ

---

№ 17/1

Улаанбаатар хот

Монголбанкны Мөнгөний бодлогын зөвлөл (МБЗ) нь 2017 оны 3 дугаар сарын 17-ны өдөр хуралдаж, хурлыг Монголбанкны Ерөнхийлөгч Н.Баяртсайхан удирдав.

МБЗ-ийн хурлаар Монголбанкны Мөнгөний бодлогын газар (МБГ)-аас гадаад эдийн засгийн орчин, макро эдийн засгийн өнөөгийн болон ойрын ирээдүйн төлөв, мөнгөний бодлогын саналыг танилцуулав. Энэ удаагийн бодлогын шинжилгээг хийхдээ ОУВС-гийн ажлын хэсгийн түвшинд тохиролцсон “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийн нөхцлүүд болон төсөв, мөнгөний бодлогын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийн нөлөөллийг тооцож үзсэний үндсэн дээр суурь төсөөллийг тооцсон.

Хятадын эдийн засгийн өсөлт өмнөх төсөөллөөс нэмэгдсэн ч хувийн секторын өрийн хэмжээ хурдацтай нэмэгдэж, экспортын төлөв байдал таагүй байгаагаас шалтгаалан өсөлт нь 2017-2018 онд саарах хүлээлттэй байна. Харин ОХУ-ын эдийн засгийн өсөлт 2017 онд нэмэгдэх, Евро бүсийн өсөлт 2017-2018 онд бага зэрэг саарах төсөөлөлтэй байна. Зэс, нүүрсний үнэ өсч 2016 онд худалдааны нөхцөл сайжирсан. 2017 онд газрын тосны үнэ нэмэгдэх хэдий ч зэс, нүүрс, төмрийн хүдрийн үнэ өмнөх улирлын түвшнээс буурч худалдааны нөхцөл эргээд муудаж болзошгүй байна.

Монгол улсын эдийн засаг 2016 оны 4 дүгээр улиралд тэвэр, хөдөө аж ахуй, худалдаа, уул уурхайн салбарын өсөлтийн нөлөөгөөр 7.8 хувиар тэлсэн бол барилгын салбар дангаараа сөрөг нөлөөтэй байв. Харин эрэлт талаас хөрөнгө оруулалт, цэвэр экспорт, хувийн хэрэглээ эерэг, засгийн газрын хэрэглээ сөрөг нөлөө үзүүллээ. Төлбөрийн тэнцлийн алдагдал 2017 онд өнгөрсөн оноос нэмэгдэх бол 2018 онд Оюу толгойн алтны агууламж эргэж сэргэн, хөрөнгийн дансны ашиг нэмэгдсэнээр алдагдал буурахаар байна.

“Хуралдай” бонд гарган Хөгжлийн банкны евро бондын дахин санхүүжилтийг амжилттай босгосноор богино хугацааны гадаад өрийн эргэн төлөлтийн дарамт багаслаа. “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийн хүрээнд зарим татварт өөрчлөлт оруулснаар энэ онд татварын орлого 203.4 тэрбум төгрөгөөр нэмэгдэх ч төсвийн алдагдлыг санхүүжүүлэх, өрийн үндсэн төлбөр төлөхөд шаардлагатай эх үүсвэрийн хэмжээ өнгөрсөн оноос өндөр хэвээр байна. ОУВС-ийн хөтөлбөрийн хүрээнд төсвийн алдагдлыг гадаад эх үүсвэрээр санхүүжүүлнэ. Ингэснээр дотоодоос шаардлагатай эх үүсвэрийн хэмжээ цэвэр дүнгээр 600 тэрбум төгрөгөөр буурна.

Жилийн инфляци суурь төсөөллөөр 2017 оны турш зорилтот түвшинд хадгалагдах хэдий ч нийлүүлэлтийн шалтгаантай хүчин зүйлс болон гадаад, дотоод орчны гэнэтийн аливаа шок нь инфляцийн төсөөллийн тодорхой бус байдлыг нэмэгдүүлж болно. МБГ-ын зүгээс эдийн засгийн дотоод болон гадаад нөхцөл, төсвийн болон мөнгөний бодлогын төлөвд үндэслэн мөнгөний бодлогын төлөвийг хэвээр хадгалах саналыг дэвшүүлэв.

МБЗ-ийн хурлаар гишүүд Мөнгөний бодлогын газрын саналыг шүүмжлэх, дэмжих хэлбэрээр хэлэлцүүлэг өрнөлөө. Мөнгөний бодлогын саналын эсрэг байр суурьтай гишүүд бодит хүү өндөр, зээлийн тасалдал үүссэн нь хүүг бууруулах шаардлагыг нэмэгдүүлж байгааг дурьдсан. Суурь төсөөллөөр инфляцийн түвшин 2017 онд Төв банкны зорилтот түвшнээс доогуур байхаар хүлээгдэж байгаа нь мөнгөний бодлогын төлөвийг зөөлрүүлэх боломжийг бий болгож байгаа. Нэгэнт ОУВС-гийн хөтөлбөрт хамрагдахаа олон нийтэд зарласан учраас бодлогын хүүг өөрчилсөн ч бусад байгууллагуудын шийдвэрт нөлөөлөхгүй гэж үзэж байлаа.

Мөнгөний бодлогын газрын саналыг дэмжсэн байр суурьтай гишүүд одоогоор хүүг өөрчлөх шийдвэр гаргахад цаг хугацааны хувьд эртдэнэ гэж үзсэн. Экспортын үнэ хүлээж байснаас сайжирч гадаад валютын орох урсгал болон хүлээлтэд эерэгээр нөлөөлж байгаа боловч энэ нь богино хугацаанд үргэлжлэхээр байна. Хэдийгээр эрэлтийн шалтгаантай инфляцийн дарамт бага, инфляци зорилтот түвшиндээ хадгалагдахаар байгаа ч ОУВС-гийн захирлуудын зөвлөл хуралдаагүй, төсвийн тодотгол хийгдээгүй байгаа нь төсвийн болон гадаад секторын тодорхой бус байдал хэвээр хадгалагдахад нөлөөлж байна. Тиймээс дээрх байдал өөрчлөгдсөн үед дахин хуралдаж бодлогын хүүний талаар шийдвэр гаргахад оройтохгүй гэж үзсэн.

Зарим гишүүдээс энэ удаагийн МБЗ-ийн хурлаас бодлогын шийдвэр гаргалгүй хүлээх саналыг дэвшүүлж байлаа.

Ийнхүү МБЗ-ийн гишүүд мөнгөний бодлогыг хэвээр хадгалах саналыг тал бүрээс нь авч үзэн хэлэлцсэний эцэст Мөнгөний бодлогын төлөвийг өөрчлөлгүй, 14.0 хувьд хэвээр хадгалах томъёоллоор санал хураахад МБЗ-ийн гишүүдийн олонхи нь уг саналыг дэмжив.

Хурлын төгсгөлд Мөнгөний бодлогын мэдэгдлийг хэлэлцэв. Мөнгөний бодлогын мэдэгдэлд “УИХ-аар 2017 оны төсвийн тодотгол, ОУВС-гийн захирлуудын зөвлөлөөр “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийг тус тус хэлэлцсэний дараа мөнгөний бодлогын төлөвийг цаашид өөрчлөх эсэхийг эргэн харах нөхцөл бүрдэнэ гэж үзэж байна” гэсэн өгүүлбэрийг тусгах нь зүйтэй гэснээр МБЗ-ийн хурал өндөрлөв.

### **ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:**

Монголбанкны МБЗ-ийн 2017 оны 3 дугаар сарын 17-ны өдрийн хурлаар Бодлогын хүүг 14.0 хувьд хэвээр хадгалах шийдвэр гаргасан. Мөнгөний бодлогын шийдвэрийг 2017 оны 3 дугаар сарын 17-ны өдрөөс эхлэн мөрдөхөөр тогтов.